

## МУЗЕЙН ЦУГЛУУЛГА ДАХЬ ГАЗРЫН ЗУРГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ НЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ БОЛОХ НЬ

Г.Энхбат

Өнөөдөр Монгол улсад улс, аймгийн болон төрөлжсөн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 40 музей байдаг ба эдгээр музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлсийн бүртгэлийг үндсэн 6 төрөлд ангилж, бүртгэн баримтжуулалтыг хийж байна. Үүнд:

1. Урлаг уран сайхан
2. Түүх
3. Угсаатны зүй
4. Шашин шүтлэг
5. Археологийн дурсгал
6. Байгалийн дурсгал

Энэ удаагийн миний илтгэх гэж буй газрын зураг, өртөө, уул, ус, газар нутгийн холбогдолтой зураглал, тэмдэглэгээ бүхий музейн үзмэр, эд өлгийн зүйл нь дээрх ангилалын “Түүх”-ийн төрөл, тэр дотроо “Баримт бичгийн дурсгал” хэмээх зүйлд хамрагдаж цаас, даавуу зэрэг бүх төрлийн материал дээр хийгдсэн баримт бичгийн дурсгалууд бүхий бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж байна.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өв гэдэг тодорхойлолтонд, түүхэн тодорхой орон зай, цаг хугацааг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд өлгийн зүйлсийг соёлын өв, түүх, соёлын дурсгалд тооцно хэмээн заасан байдаг. Тэгвэл газрын зураг, газар дүрсийн тэмдэглэгээ, өртөө, харуулын чиглэл зэргийг цаас, даавуун дээр зурж тэмдэглэсэн баримт нь тухайн орон нутгийн хил хязгаар, газар усны оноосон нэрийг тухайн түүхэн цаг үе, засаг захиргааны нэгжийнх нь нэрний хамт батлан үлдээсэн түүхэн ач холбогдолтой болохын сацуу түүнийг тэмдэглэн, зурж дүрслэхдээ монголын дүрслэх урлагийн уламжлалт хавтгай хэмжээст, монгол зургийн аргаар өнгө будаг ялган зурсан байдгаараа уран сайхны соёл, урлаг, урлахуйн ухааны ач холбогдолтойг давхар нотлон харуулсан гэж үзэж байна.

Музей нь түүх, соёлын дурсгалд тооцогдох эд өлгийн зүйлсийг цуглуулан хадгалахаас гадна олон нийтэд соёлын өвийн мэдлэг боловсрол олгох, үнэн бодит түүхийг мэдээлэх зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг. Газрын зургаас бид өнөөдрийн Монгол

---

Г.Энхбат

Соёлын өвийн төв  
enkhbat@monheritage.mn

**Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар**

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд  
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

улсын засаг захиргааны нэгжийн хувиарлалт болоод түүнээс өмнөх үеийн түүхийн засаг захиргааны нэгжийн хувиарлалт нь хэрхэн хийгдэж байсан, энэ нь улс, төр, нийгэм, эдийн засаг, байгаль газар зүй, мал аж ахуй, нүүдэлчний соёлын хувьд ямар ач холбогдолтой, онцлог шинжтэй байсан талаарх мэдээллийг харьцуулах, хувь хүн өөрийн ураг, овог угсааны гарлын талаар мэдлэг олж авах зэрэг олон талын мэдээлэл, мэдлэгийг олж авах боломжтой юм.

Монгол зургийн хэлбэрээр зурагдсан газрын зурагт уул усны нэрний соёл, нэрний агуулга, угсаа гарвал зэрэг нь тухайн газрын байгалийн баялаг, эрдэнэсийг шууд утгаар нь нэрлэх, уул, ус газрын байршил, түүний харагдах хэлбэр төрхийг хүчирхэг амьтнаар билэгдэн дүрслэх, улсын болон орон нутгийн хилийн дээс цэгүүдийг тэмдэглэн үлдээсэн байдал нь улс, эх орны халдашгүй дархан байдлыг харуулсан гэх мэт олон төрлийн мэдээлэл газрын зургаас харж болно.

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 2012 оны 4 сарын байдлаар улс, аймгийн музейн сан хөмрөгт нийт 15 музейн 44 ширхэг газрын зургийн холбогдолтой үзмэрийн мэдээлэл хадгалагдаж байна. Жагсаалтаар үзүүлвэл,

Д/д	СӨУНБМС-дугаар	Эзэмшигч	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Он цаг	
1	1122БОМ	2536	Богд хааны ордон музей	Газрын зураг	1/8/2001	XX зууны эхэн үе
2	1122БОМ	2537	Богд хааны ордон музей	Газрын зураг	1/8/2002	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
3	1119ТТМ	48	Төрийн Түүхийн музей	Эзэнт гүрний зоосны газрын зураг-1	T08L085 - 01	Юан гүрний үе /1271 - 1368 он/
4	1119ТТМ	72	Төрийн Түүхийн музей	Эзэнт гүрний зоосны газрын зураг-2	T08L086 - 01	Юан гүрний үе /1271 - 1368 он/
5	1119ТТМ	363	Төрийн Түүхийн музей	Монгол аймгууд газрын зураг	T07C349 - 01	Монгол Улсын үе / 1992 оноос хойш/
6	1119ТТМ	366	Төрийн Түүхийн музей	Олноо өргөгдсөн Монгол Улс газрын зураг	T07C350 - 01	Монгол Улсын үе /1992 оноос хойш /
7	1125БТМ	763	Байгалийн Түүхийн музей	Загасны тархалтын газрын зураг	T-02-60	Монгол Улсын үе /1992 оноос хойш /
8	1125БТМ	764	Байгалийн Түүхийн музей	Ан амьтны тархалтын газрын зураг	T-03-384	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
9	1110МЦМ	351	БХЯ-ний харьяа Монголын цэргийн музей	Газрын зураг-Монголын эзэнт гүрэн	Ү-96-10-18	
10	6401БХМ	338	Баянхонгор аймгийн музей	Баянхонгор газрын зураг / сийлбэр/	69-4-42	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
11	6401БХМ		Баянхонгор аймгийн музей	Монгол улсын өндөр нам уул усны газрын зураг	97-2-2	1924 он
12	6401БХМ	961	Баянхонгор аймгийн музей	Газрын зураг / МУын /	97-2-1	Богд Хаант Монгол улсын үе /1911 - 1924 он /

13	8201ГАМ	523	Говь-Алтай аймгийн музей	МАХН-н 50-н жилд зориулсан газрын зураг	ГА.Т78,46	БНМАУ-ын үе /1924 - 1992 он /
14	8201ГАМ	529	Говь-Алтай аймгийн музей	Хувьсгалт залуучуудын эвлэл 50-н жилийн газрын зураг	ГА.Т78,48	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
15	4501ДАМ	280	Дархан-Уул аймгийн музей	Хүннү газрын зураг	03,14	Монгол Улсын үе /1992 оноос хойш /
16	4501ДАМ	281	Дархан-Уул аймгийн музей	Сяньби улсын газрын зураг	03,15	Монгол Улсын үе /1992 оноос хойш /
17	4501ДАМ	282	Дархан-Уул аймгийн музей	Түрэг улсын газрын зураг	03,16	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
18	4501ДАМ	283	Дархан-Уул аймгийн музей	Уйгар газрын зураг	03,17	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
19	4501ДАМ	284	Дархан-Уул аймгийн музей	Хятан газрын зураг	03,18	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
20	4501ДАМ	740	Дархан-Уул аймгийн музей	Дэлхийн газрын зураг	3.2	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
21	4501ДАМ	741	Дархан-Уул аймгийн музей	Монгол газрын зураг	3.19	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
22	2101ДОМ	1024	Дорнод аймгийн музей	Газрын зураг	Мау-47	Монгол Улсын үе / 1992 оноос хойш /
23	2101ДОМ	1054	Дорнод аймгийн музей	Сэцэн хан аймгийн газрын зураг	89-03	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
24	2101ДОМ	1063	Дорнод аймгийн музей	Газрын зураг	60-118	1926 он
25	2101ДОМ	796	Дорнод аймгийн музей	Хан Хэнтий уулын аймаг / Газрын зураг/	89-13	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
26	2101ДОМ	431	Дорнод аймгийн музей	Ашигт малтмалын газрын зураг	89-46	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
27	4801ДУМ	653	Дундговь аймгийн музей	Газрын зураг	Ү 67.1.36	ХҮП зууны сүүл үе
28	4801ДУМ		Дундговь аймгийн музей	Харчин өртөөний тойм зураг	Ү 67.1.37	Богд Хаант Монгол улсын үе /1911 - 1924 он/
29	8101ЗАМ	204	Завхан аймгийн музей	завхан аймгийн газрын зураг	93-01	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
30	4601ӨММ	187	Өмнөговь аймгийн музей	Ногоон газрын зураг	08-71-20	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
31	4601ӨММ	207	Өмнөговь аймгийн музей	Газрын зурагнууд	60-74	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
32	4601ӨММ	274	Өмнөговь аймгийн музей	Газрын зураг	60-73	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
33	4601ӨММ	276	Өмнөговь аймгийн музей	Газрын зурагнууд	6076	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/

34	4601ӨММ	635	Өмнөговь аймгийн музей	МУ-ын газрын зураг	60-71	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
35	4101ТӨМ	988	Төв аймгийн музей	Газрын зураг танилцуулга	07-877	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
36	4101ТӨМ	1099	Төв аймгийн музей	Ц.Жамсран газрын зураг дээр ярьж байгаа нь	Mar-89	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
37	4101ТӨМ	1341	Төв аймгийн музей	Ан амьтан байршил газрын зураг	07-563	Монгол Улсын үе /1992 оноос хойш/
38	8401ХОМ	27	Ховд аймгийн музей	Монгол нутагт үүссэн анхны төрт улсуудын газрын зураг	90.03	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
39	8401ХОМ	135	Ховд аймгийн музей	Монгол нутагт үүссэн анхны төрт улсуудын газрын зураг	90,03	Хамаг Монгол улсын үе /XII зуун/
40	6701ХӨМ	987	Хөвсгөл аймгийн музей	Цагаантныг бут цохисон газрын зураг	T - 67 - 26	XX зууны дунд үе
41	6701ХӨМ	1771	Хөвсгөл аймгийн музей	Цэцэрлэг сум нутгийн газрын зураг	Y - 60 - 01	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
42	6701ХӨМ	302	Хөвсгөл аймгийн музей	Монгол орны газрын зураг	Y - 54 - 03	Богд Хаант Монгол улсын үе /1911 - 1924 он/
43	2301ХЭМ	721	Хэнтий аймгийн музей	Сэнгүр горхи түүхэн дурсгалт газрын зураг	90-33-2	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/
44	2301ХЭМ	723	Хэнтий аймгийн музей	Дэлүүн болдог түүхэн дурсгалт газрын зураг	90-33-3	БНМАУ-ын үе /1924 - 1992 он/

**Нийт 15 музейн 44 дурсгал**

Музейн сан хөмрөгт байгаа эдгээр газрын зурагтай холбоотой үзмэрийг төрөлжүүлэн ангилах, сэргээн засварлах, дутуу байгаа түүхийн олон үед хамрагдах газрын зургийг улсын сан хөмрөгт бодлогоор цуглуулах шаардлагатай юм.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь цаашдаа зөвхөн музейн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас гадна төрийн болон орон нутгийн өмчит түүх, соёлын дурсгалт зүйл байж болох 150 орчим байгууллагаас энэхүү чиглэлийн мэдээллийг олж аван мэдээллийн сангаа баяжуулах зорилготой ажиллаж байна.